| | | дүнгийн гэрээг дүгнэсний дараа сэлгүүлэх зэрэг арга хэмжээ авна. Хорооны ажилтнуудын үр дүнгийн гэрээ хараахан дүгнэгдээгүй байна.<br>-Нийт ажилтнууд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын захирлууд, ЭБАТ-уудыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль бусад холбогдох хууль, дүрэм журмыг таньж мэдүүлэх зорилгоор арга зүйгээр байнга хангаж ажиллав.<br>-Авто зам засвар арчлалт болон эрчим хүчний ТӨХК-уудын гүйцэтгэх захирлуудад хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн бөглөх болон хуулийн хэрэгжилтийн талаарх сургалтыг 2014 онд АТГ-тай хамтран зохион байгуулав.<br>-Нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд, үйлдвэрийн газруудын захирлуудтай байгуулсан Хөлсөөр ажиллах гэрээнд Авлигын хуулийг дагаж мөрдөх заалтыг нэмж оруулсан.<br>-Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад Мэдээллийг ил тод байдал талаар албан бичиг хүргүүлсэн.<br>-Авлигын эсрэг хуулийг дагаж мөрдөх талаар албан бичгийг Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад удаа дараа явуулсан.<br>-Нийт албан тушаалтнуудад сургалтыг удаа дараа зохион байгуулсан. |
| 7.1.18 | Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх | 1.Зөрчлийг нэн даруй мэдээлэх талаар холбогдох ажилтнуудад танилцуулах /байгууллага, албан тушаалтнаас АТГ-т шалгуулахаар харъяаллын дагуу шилжүүлсэн материалд үндэслэн үнэлэх/<br>Танилцуулсан.<br>2.АТГ-аас хийсэн шалгалтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд мэдээлээгүй буруутай этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэсэн байдал<br>Байхгүй |
| 7.1.19 | Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглох | Авлигатай тэмцэх газраас Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “төрийн байгууллагын байрлаж байгаа байранд түүний үйлчилгээ эрхэлдэгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно” гэсэн заалтын дагуу Зөвлөмж ирсэн. Уг Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна. |

| | | |
|---|---|---|
| 7.1.20 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх | 1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний үр дүн<br>Авлигатай тэмцэх газраас Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “төрийн байгууллагын байрлаж байгаа байранд түүний үйлчилгээ эрхэлдэгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно” гэсэн заалтын дагуу Зөвлөмж ирсэн бөгөөд уг Зөвлөмжийг хэрэгжүүлж, Төрийн өмчийн хорооноос 2013.01.04-ний өдрийн 3/19 тоот албан бичгээр түрээсийн гэрээний талаар албан бичгийг бүх төрийн өмчит болон улсын төсөвт хуулийн этгээдийн дарга, захирал нарт явуулсан.<br>2.АТГ, Цагдаа, Прокурорын дэргэдэх мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг тооцож ажиллах<br>Байхгүй<br>3.АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг хүргүүлэх<br>Авлигын эсрэг хуулийн заалтыг зөрчсөн нэр бүхий албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан бичгийг “Автоимпекс” ХХК, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж, хариуг 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1в/894 тоотоор Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн./Уг албан тушаалтнуудыг ажлаас чөлөөлсөн/<br>-Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах тухай 2014.06.30-ны өдрийн 12 тоот мэдэгдэл ирсэн бөгөөд уг мэдэгдлийн дагуу Төрийн өмчийн хороо төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад төрийн төлөөлөл хэрэгжүүлэн ажиллаж байгаа Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тогтоосон цалин хөлснөөс өөр төрлийн шан харамж, урамшуулал, хандив, бэлэг өгөхгүй байх талаар төрийн өмчийн бүхий л компаниудад албан даалгавар 2014.07.08-ны 1а/1998 тоотоор хүргүүллээ.<br>-Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн бэлтгэл хангуулах тухай 2014 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 02/6482 тоот албан бичиг, хавсралтын дагуу компани /үйлдвэрийн газар/ худалдан авах ажиллагаа болон төсвийн талаарх мэдээллийг 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбартаа ил тод нээлттэй байршуулж ажиллахыг мэдэгдсэн албан бичгийг 2014.08.25-ны өдрийн 1в/2273 тоотоор ТӨХК, үйлдвэрийн газруудад мэдэгдсэн.<br>-Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай 2014.07.18-ны өдрийн 05/5981 тоот албан бичгийн дагуу “Завхан АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал М.Болдтой холбоотой асуудлаар ТУЗ-д |

| | | |
|---|---|---|
| | | уламжилсан бөгөөд АТГ-ын 2014 оны 03/4271 тоот албан бичгийн дагуу М.Болдод хариуцлага тооцсон тухай ТУЗ-ийн тогтоолыг хүргүүлэв.<br>-Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2014 оны 05/6048 тоот албан бичиг АТГ-аас ирсэн бөгөөд уг албан бичгийн дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооноос хараат бус гишүүнд нэр дэвшиж сонгон шалгаруулалтад тэнцсэн хүний Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг холбогдох материалын хамт Төрийн өмчийн хороон дээр хүлээн авч, Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, дүгнэлт гаргуулах болсон талаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нарт анхааруулсан албан бичгийг 2014.09.05-ны өдрийн 1а/2364 тоотоор хүргүүлэв.<br>- Авлигатай тэмцэх газраас хуулийн хэрэгжилтийг хангах тухай 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 03/7007 тоот албан бичгийг манайд ирүүлсэн.Уг албан бичигт Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дурдсан арга хэмжээ авч, Зөвлөмжид дурдсан заалт тус бүрээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон бөгөөд хариуг хүлээн авч ажиллалаа.<br>4.АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг хариуцах<br>АТГ-аас хариуцлага тооцуулах тухай албан бичгийн биелэлтийг хорооны эрх бүхий албан тушаалтан Х.Нарангарав хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>5.АТГ-аас авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох<br>Байхгүй<br>6.АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын биелэлт<br>Байхгүй |

| | | |
|---|---|---|
| 7.3.1 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлтыг нэмэгдүүлэх | 1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдэх<br>Төрийн өмчийн хорооноос "Авлигын эсрэг Уриалга"-ыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд, үйлдвэрийн газруудад хандаж гаргаж, spc.gov.mn цахим хуудаст мэдээллээ.<br>2. Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан хөрөнгө зарцуулсан байх<br>2014 оны 10 дугаар сард Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх төрийн албаны инстиутиэс "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил" сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд багш нарын цалин хөлсийг хорооноос гаргаж шийдвэрлэсэн.Мөн Хуульчдын холбооны Өмгөөлөгчдийн хороотой хамтран байгуулах санамж бичигт авлигын эсрэг хамтран ажиллах заалт оруулж байгаа бөгөөд хөрөнгө зарцуулахаар бэлтгэж байна. Авлигын эсрэг үйл ажиллагаа, арга хэмжээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тусгайлан ЭБАТ-ыг өрөө, сав, сейф, нэмэгдэл, бичиг хэргийн зардал зэргийг олгосон.<br>-ТӨХ-ны зүгээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд, үйлдвэрийн газруудад ТӨХ болон АТГ-ын зүгээс байнга Авлигын эсрэг хууль, холбогдох дүрэм журмуудаар сургалт зохион байгуулж байна. |
| 7.3.2 | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх | 1.Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/ зохион байгуулах<br>-Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам" мөрдөгдөж байгаатай холбогдуулан 2014 оны 01 дүгээр сард Авлигатай тэмцэх газрын заалзнд Авлигатай тэмцэх газартай хамтран төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд /ТӨҮГ/-ын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, эрх бүхий албан тушаалтнуудын нэгдсэн сургалтыг зохион байгуулсан.<br>-Авлигатай тэмцэх газраас албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, "Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн мэдээллийн систем" ашиглах, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн талаархи сургалтыг хорооны нийт ажилтнуудад Авлигатай тэмцэх газар, НДЭХ-той хамтран ТӨХ-ны ажилтнуудад Авлигын эсрэг хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүтэн 1 өдрийн сургалт 2014 оны 1 дүгээр сард зохион байгуулав.<br>-Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд /ТӨҮГ/-ын мэдүүлэг гаргагч |

| | | |
|---|---|---|
| | | албан тушаалтнуудад 2014 онд АТГ, Төрийн өмчийн хороонд хүсэлт тавьсан даруйд сургалт зохион байгуулж ажиллалаа.<br>-Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил сэдвээр сургалт зохион байгуулав.<br>2.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчилд арга хэмжээ шуурхай авах<br>Байхгүй<br>3.Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчилд хариуцлага тооцож ажиллах<br>Байхгүй<br>4.Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчилд хариуцлага тооцож ажиллах /Мэдэгдэл авах/<br>Байхгүй |
| 7.3.3 | Төрийн өмчит хуулийн этгээдүүдэд Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжлтийг хангуулж ажиллах | -Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.5 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн гишүүн болон хараат бус гишүүнд сонгогдохоор нэр дэвшигчдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр хянуулсан.<br>-Томилогдож буй захирал, гүйцэтгэх захирлын мэдүүлгийг тухай бүр мэдүүлж, хянуулан хорооны хурлаар шийдвэрлүүлэхээр ажиллав.<br>-Авто зам засвар арчлалт болон эрчим хүчний ТӨХК-уудын гүйцэтгэх захирлуудад хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн бөглөх талаар болон хуулийн хэрэгжилтийн талаар сургалтыг 2014 онд АТГ-тай хамтран зохион байгуулав.<br>-Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн захирал, гүйцэтгэх захирал нартай байгуулах гэрээнд "Гүйцэтгэх захирал Авлигын эсрэг хууль, Нийтийн албанднийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд мөрдөн ажиллана" гэсэн заалт оруулсан. |
| 7.3.4 | Сайн туршлага судлах | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд, үйлдвэрийн газруудын захиргаа удирдлага, зохион байгуулалтын ажилтай танилцаж, мониторинг үнэлгээ хийх ажлын хэсэгт орж ажилласаны дагуу Хорооны даргын 280 дугаар тушаалын биелэлтийг шалгахдаа Авлигын эсрэг хууль, түүнтэй холбоотой хууль дүрэм журмыг дагаж мөрдөж байгаа компани, үйлдвэрийн газруудын үйл ажиллагаатай биечлэн танилцсан болно. |

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

/Х.НАРАНГАРАВ/

The Asia Foundation

# ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНД

2014 оны 7 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Юуны өмнө Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. АНУ-ын Азийн Сан нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Засаглал, ил тод байдлыг дэмжих төслийг 2012 оны 9 сараас эхлэн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, авлигын эсрэг болон захиргааны шинэчлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа билээ.

Тус сан өмнө нь явуулж байсан Авлигын түвшин тогтоох судалгаагаа “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа” нэртэйгээр дээрх төслийн хүрээнд үргэлжлүүлж байгаа бөгөөд 15 дахь удаагийн судалгааны үр дүнг та бүхэнтэй хуваалцахдаа таатай байна. Түүнчлэн “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” судалгааны 4 дахь удаагийн судалгааны үр дүнг хүргүүлж байна.

Танд эрүүл энх, сайн сайхан, ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн,

Суурин Төлөөлөгч
Мелони К. Линдберг

Жич: Судалгааны талаархи нэмэлт мэдээллийг solongo.otgonbayar@asiafoundation.org хаягаар хандаж авна уу.

Orient Plaza 3rd Floor, G.Chagdarjav Street 9 | Central P.O. Box 1003 | Ulaanbaatar 14210
Tel: 976 (11) 330-524 | Fax: 976 (11) 311-497 | www.asiafoundation.org

МОНГОЛ УЛС
**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**
14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2013.12.23 № 08/10001

танай ____________-ны №____________-т

ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЦОГТБААТАР ТАНАА

Авлигатай тэмцэх газраас "Нийгмийн дэвшлийн эмэгтэйчүүд" хөдөлгөөнтэй хамтран Авлигын эсрэг хууль хууль тогтоомжийг таниулах, өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон хэрэглэх, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг олгох сургалтыг 2014 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөөд байна. Иймд энэхүү сургалтад байгууллагынхаа 25-30 ажилтанг хамруулж хамтран ажиллахыг хүсье.

Хөтөлбөрийг хавсаргав.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР Б.ДОНЬЖЧИМБУУ

# СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

## Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь: Нийтийн албан тушаалтанд зориулсан сургалт

| | |
|---|---|
| Хугацаа | 2014 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр |
| Байршил | Ардчиллын ордны сургалтын танхимд. |
| Зохион байгуулагч | Авлигатай тэмцэх газар<br>АНУ-ын Азийн сан<br>Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн |
| Оролцогчид | Төрийн өмчийн хорооны ажилтнууд |
| Зорилго | Нийтийн албан тушаалтнуудад авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах, эдгээрийг өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгож хэрэглэх, авлига болон ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аливаа хууль бус үйлдлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, мэдээлэл өгөх. |

**Жич: Сургалтын зохион байгуулалттай холбоотой мэдээллийг 70135741 дугаарын утсаар холбогдож лавлана уу. /А.Мөнхнарантай ярих/**

| | |
|---|---|
| *08:40 – 09:00.* | *Оролцогчдыг бүртгэх*<br>Н.ОЮУНЧИМЭГ<br>Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн, Төслийн ажилтан |
| *09:00 – 09:15.* | *Сургалтыг нээх*<br>С.ОЮУНТУЯА<br>Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн, Захирал<br><br>А.ДЭЛГЭРБАЯР<br>Авлигатай тэмцэх газар, Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар<br>Тухайн байгууллагын удирдлага/Эрх бүхий албан тушаалтан |
| *09:15 – 09:25.* | *"Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь: Нийтийн албан тушаалтны гарын авлага"-ын танилцуулга*<br>А.МӨНХНАРАН<br>Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн, сургалтын менежер |
| *09:25 – 09:40.* | *Танилцах дасгал*<br>А.МӨНХНАРАН<br>Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн, сургалтын менежер |
| *09:40 – 10:30* | *Төрийн байгууллага ил тод байдлаа хэрхэн хангах вэ?*<br>Т.ЦОЛМОН<br>Авлигатай тэмцэх газар, Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар |

2014 8719

Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн 2013 он

| | | |
|---|---|---|
| 10:30 – 11:00. | ***Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?*** | А.ДЭЛГЭРБАЯР<br>Авлигатай тэмцэх газар, Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар |
| 11:00 – 11:20. | ***Цайны завсарлага*** | Оролцогчид<br>“Гэр” ресторан |
| 11:20 – 12:30. | ***Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?*** | А.ДЭЛГЭРБАЯР<br>Авлигатай тэмцэх газар, Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар |
| 12:30 – 13:30 | ***Үдийн хоол*** | Оролцогчид<br>“Гэр” ресторанд /МоАХ-ын байрны урд талд/ |
| 13:30 – 14:30 | ***Ашиг сонирхлын зөрчлийн хориглолт, хязгаарлалт*** | Д.МӨНХЖАРГАЛ<br>Авлигатай тэмцэх газар, Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар |
| 14:30 – 15:50 | ***Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг:*** *Хэзээ, Хэрхэн мэдүүлэх вэ?* | Б.ӨЛЗИЙ<br>Авлигатай тэмцэх газар, Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар |
| 15:50 – 16:10 | ***Цайны завсарлага*** | Оролцогчид |
| 16:10 – 17:10 | ***Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, Ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх мэдэгдэл, тайлбарыг ямар тохиолдолд хэрхэн гаргах:*** | Б.ӨЛЗИЙ<br>Авлигатай тэмцэх газар, Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар |
| 17:10 – 17:30 | ***Бид өнөөдөр юу сурав? Сурснаа хэрхэн ашиглах вэ?*** *Үнэлгээ хийх дасгал ажил* | А.МӨНХНАРАН<br>Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн, сургалтын менежер |

*Баярлалаа.*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**МОНГОЛ УЛСЫН**
**ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 5/2, Засгийн газрын IV байр, Утас: 263538,
Факс: 31-27-98, E-mail: info@spc.gov.mn

2014.09.24 № 1б/2519

танай ____________-ны № ____________-т

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ИНСТИТУТИД

Төрийн өмчийн хорооны ажилтнууд ёс зүйн мэдлэгээ өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох зорилтын хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт сургалтыг манай ажилтнуудад 2014 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 08 цаг 30 минутаас зохион байгуулж өгөхийг хүсье.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ОДМАА

C:\My Documents\Blank A5

0004513

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 5/2, Засгийн газрын IV байр, Утас: 265839,
Факс: 31-27-98, E-mail: info@spc.gov.mn

2014.09.26 № 10/2541

танай ____________-ны № ____________-т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР
Б.ДОНЬЖЧИМБУУ ТАНАА

Хуулийн хэрэгжилтийг
хангаж ажиллаж байгаа тухай

Хуулийн хэрэгжилтийг хангах тухай 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 03/7007 тоот албан бичигтэй танилцлаа.

Дээрх албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

-Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасны дагуу нийтийн албанд томилохдоо хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудаас авч, хянуулж томилж байна;

-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулахад оролцох бүрт болон захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тохиолдолд тус тус "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг маягтын дагуу гаргуулж байна;

-Мэдүүлэг гаргагч тус бүрээс нийтийн албанд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үрэд, оны байдлаар цаасаар болон цахимаар гаргуулж, гарын үсэг зуруулан, бүртгэлийг хөтөлж байна;

-Авлигын эсрэг хуульд заасанаар 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөс хойшхи хугацаанд их хэмжээний өөрчлөлт мэдүүлэг гаргагчийн хөрөнгө орлогод орсон 30 хоногийн дотор шинэчлэн гаргуулж, энэ тухай мэдээллийг цаасаар болон цахимаар програмд баталгаажуулж, бүртгэж байна.

-Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны чиг үүргийг хуулийн мэргэжилтэн Х.Нарангаравт хариуцуулсан шийдвэр гарсан бөгөөд чиг үүргийг нь ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусгаж, нууцын баталгаа гаргуулан ажиллаж байна;

-Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд Төрийн өмчийн хороонд мэдэгдсэн тохиолдолд мэдүүлгийн цахим програмд хасалт хийж, шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтны мэдээллийг цахим програмд шинэчлэн оруулж байна;

C:\My Documents\Blank A4

0006930

-Ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар гаргасан мэдэгдэл, тайлбарууд, бусад мэдүүлэг түүнтэй холбоотой тайлан, бүртгэлийг хадгалах зориулалтын сейф, лац, тэмдэгээр бүрэн хангасан;

-"Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэл", "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл", "Мэдэгдэл. тайлбар. мэдээлэл шийдвэрлэлтийн бүртгэл"-үүдийг тухай бүр цахим болон цаас хэлбэрээр хөтөлж, мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудаас ашиг сонирхлын асуудлаар гаргасан мэдэгдэл, тайлбар, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь гаргуулан, гарын үсэг зуруулж, баталгаажуулан, цахим програм дахь холбогдох мэдээллийг тогтмол шинэчилж бүртгэж байна;

-Мэдүүлэг гаргагч болон салбар, нэгжийн эрх бүхий албан тушаалтнуудын шилжилт хөдөлгөөнийг мэдүүлгийн цахим програмд тогтмол бүрэн шинэчилж;
холбогдох хууль тогтоомжийг таниулах чиглэлээр 2014 оны 01 дүгээр сард Авлигатай тэмцэх газрын хурлын танхимд Авлигатай тэмцэх газартай хамтран төрийн эмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд /ТӨҮГ/-ын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, эрх бүхий албан тушаалтнуудын нэгдсэн сургалтыг зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газраас албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, "Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн мэдээллийн систем" ашиглах, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг таниулах талаархи сургалтыг хорооны нийт ажилтнуудад Авлигатай тэмцэх газар, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн холбоотой хамтран Төрийн өмчийн хорооны ажилтнуудад бүтэн 1 өдрийн сургалт 2014 оны 1 дүгээр сард зохион байгуулсан бөгөөд гарын авлагыг нийт эрх бүхий албан тушаалтнууд, мэдүүлэг гаргагч нарт тараан өгсөн;

-Байгууллагын нэгж дотроо ажлын байрны тодорхойлолт. эрхлэх асуудлын чиг үүрэг нь өөрчлөлт орж шилжүүлэх болон сэлгэн томилох, туршилтын хугацаагаар буюу түр орлон гүйцэтгэгчээр томилохдоо урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж байна;

-Мөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 84 хуулийн этгээдэд хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай Авлигатай тэмцэх газрын 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 03/7007 тоот албан бичгийг явуулж, хуулийг хэрэгжүүлж ажиллахыг анхааруулж ажиллав.

Хавсралт: 1 хуудас.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЦОГТБААТАР

C:\My Documents\Blank A4

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 5/2, Засгийн газрын IV байр, Утас: 265839,
Факс: 31-27-98, E-mail: info@spc.gov.mn

2014.07.08 № 1а/1998

танай ____________-ны № ____________-т

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИУДЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ НАРТ

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглосон.

Иймд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад төрийн төлөөлөл хэрэгжүүлэн ажиллаж байгаа Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тогтоосон цалин хөлснөөс өөр төрлийн шан харамж, урамшуулал, хандив, бэлэг өгөхгүй байх, Авлигын эсрэг хуулийн 7.1 дэх хэсэгт заасан зөрчлийг хориглох, цаашид Авлигын эсрэг хууль, "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөх, ийм төрлийн зөрчил гаргуулахгүй байхад анхаарч ажиллахыг мэдэгдэж байна.

Мөн түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж байхыг дахин анхааруулж байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЦОГТБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 5/2, Засгийн газрын IV байр, Утас: 265839,
Факс: 31-27-98, E-mail: info@spc.gov.mn

2014.09.05 № 10/2364

танай ____________-ны № ____________-т

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НАРТ

Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай

Авлигатай тэмцэх газраас 2014 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн 05/6048 тоотоор хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан бичгийг тус хороонд ирүүлсэн.

Уг албан бичигт төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, дүгнэлт гаргуулахгүй томилж байгаа талаар дурдсан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасны дагуу танай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооноос хараат бус гишүүнд нэр дэвшиж, сонгон шалгаруулалтад тэнцсэн хүний Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэгт заасан баримт бичгийн хамт бүрдүүлж ирүүлсэн материалыг *Төрийн өмчийн хороо* хүлээн авч, Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, дүгнэлт гаргуулах болсон тул хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг анхааруулж байна.

Жич: Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, /нарийн бичгийн дарга/-нарт танилцуулах.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЦОГТБААТАР

C:\My Documents\Blank A4

0005878

МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 5/2, Засгийн газрын IV байр, Утас: 263538,
Факс: 31-27-98, E-mail: info@spc.gov.mn

2014.08.15 № 1б/2218

танай ________ -ны № ________

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН
ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ
КОМПАНИД

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн бэлтгэл хангуулах тухай 2014 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 02/6482 тоот албан бичиг, хавсралтын дагуу танай компани /үйлдвэрийн газар/ худалдан авах ажиллагаа болон төсвийн талаарх мэдээллийг 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбартаа ил тод нээлттэй байршуулж ажиллахыг үүрэг болгож байна.

Хавсралт 3 хуудас.

ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.ОДМАА

C:\My Documents\Blank A5

Бэлтгэл хангуулах тухай

Авлигатай тэмцэх газраас 2013 онд Авлиг…
18.1.1-д заасны дагуу төрийн байгууллагаас х…
ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх аргачлал…
шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгож, түү…
нутгийн захиргааны байгууллагуудыг хөндлөнгийн…
нийтэд нээлттэй зарлах ажлыг анх удаа зохион бай…

Энэхүү аргачлалын дагуу авлигын эсрэг үйл…
шинжээчдээр үнэлүүлэх бөгөөд 2014 оны үнэлгээ 11…